

МОНГОЛ АЛТАЙН НУРУУНЫ УТХГ-ЫН ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ
2020 ОНЫ 03 ДУГААР САРЫН 2 ДАХЬ 7 ХОНОГИЙН

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Салбарын бодлогийн хэрэгжилтийг зохицуулах чиглэлээр

1. Хамгаалалтын захиргааны даргын 2020 оны 03- р сарын 05-ны өдрийн баталсан удирдамжийн дагуу Алтай Таванбогдын БЦГ-ын Орчны бүс дахь хамгаалалтын захиргааны ойжуулалтын талбайд өвөлжиж буй 7 тооны Халиун бугын сүрэгт 1 цэгт 100 кг давс тавьж биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэв. Үүнээс гадна Алтай Таванбогдын БЦГ-ын Могойт, Онхад, Баянзүрх орчмын Халиун бугын амьдрах орчин, шилжилт хөдөлгөөн, тархац нутагт ажиглалт мониторинг явуулж Баянзүрх ууланд 1 цэгт 200 кг давс тавьж биотехникийн арга хэмжээ авч ажиллав.
2. Тусгай хамгаалалттай газар нутагт нүүж очсон 23 айл өрхүүдэд орж, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль болон байгалийн цогцолборт газрын хамгаалалтын горим, дэглэмийг хангуулах, хууль бусаар мод бэлтгэх, ан агнах зөрчил гаргуулахгүй байх талаар давхардсан тоогоор 60 хүнд яриа хийв.
3. Ой, хээрийн түймрийн аюултай үед Халиун бугын цусан эврийг түүхгүй байх Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 04 дүгээр сарын 20-ны А/97 тоот тушаалын хэрэгжилтийг хангуулах талаар сурталчилгаа хийж, сэрэмжлүүлэг, анхааруулга бүхий 23 ширхэг тараах материалуудыг тарааж ажиллав.
4. Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх шийдвэрүүдийн биелэлтийг ханган ажиллаж байна.

МАНУТХГ-ын Хамгаалалтын Захиргаа